



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 09

Мандалговь

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.6, 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арваннаймдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 26,579,151,54 (хорин зургаан сая таван зуун далан есөн мянга нэг зуун тавин нэгэн төгрөг тавин дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэтэй, 19,491,377,94 (арван есөн сая дөрвөн зуун ерэн нэг мянга гурван зуун далан долоон төгрөг ерэн дөрвөн мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөгтэй зочид буудлыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Өндөршил сумын Засаг дарга (У.Алтанхүү), Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Амгаланжаргал) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Үл хөдлөх хөрөнгө акталснаас гарсан материалыг сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор эргэлтийн хөрөнгөд бүртгэх, худалдан борлуулах, худалдсанаас орсон орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд 100 хувь төвлөрүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн
09 дугаар тогтоолын хавсралт

Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын Актлах хөрөнгийн мэдээдлэл

| д/ д | Хөрөнгийн нэр | Ашиглал тад орсон огноо | Хэмж их нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Балансны үнэ | Хуримтлагдс ан элэгдэл | Үлдэгдэл өртөг | данснаас хасах болсон шалтгаан | Актлах төрөл /1.Устгах 2.худалдах 3.Сэлбэг материал,хоёр догч түүхий эд болгон ашиглах 4.бусад / |
|----------|------------------|----------------------------------|--------------------|---------------|---------------|--|---|---|---|---|
| 1 | Зочид буудал | 1964 | ш | 1 | 26,579,151.54 | 26,579,151.54 | 7,087,773.60 | 19,491,377.94 | Барилгын тухай хуулийн шаардлагыг хангахгүй байгаа. Мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргасан. | 3 |
| Нийт дүн | | | | | | 26,579,151.54 /хорин зургаан сая таван зуун далан есөн мянга нэг зуун тавин нэгэн төгрөг тавин дөрвөн мөнгө/ төгрөг | 7,087,773.60 /долоон сая нэг наян долоон мянга долоон зуун далан гурван төгрөг жаран мөнгө/ төгрөг | 19,491,377.94 /арван есөн сая дөрвөн зуун ерэн нэг мянга гурван зуун далан долоон төгрөг ерэн дөрвөн мөнгө/ төгрөг | | |